

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-15

- | | |
|---|-------|
| 1. Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын
“Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төсөл
/Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн,
зөвшилцөх, санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй
байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/ | 4-14 |
| 2. Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг
байгуулах тухай/ | 14-15 |
-

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
09 дүгээр сарын 16-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Б.Заяабал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 51 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: С.Цэнгүүн;

Чөлөөтэй: Н.Батсүмбэрэл, Б.Уянга;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Баатархүү;

Тасалсан: Ш.Бямбасүрэн, Б.Жаргалан, Ч.Лодойсамбуу, Э.Одбаяр, Г.Очирбат, Б.Пунсалмаа, Р.Сэддорж, О.Цогтгэрэл.

Нэг.Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төсөл /Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хорооны асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Я.Эрдэнэсамбуу, зөвлөх Л.Батмөнх, референт Б.Алтан, С.Тэгшжаргал, Х.Шижирмөнх нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд З.Мэндсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Г.Лувсанжамц, Л.Соронзонболд, Б.Мөнхсоёл, С.Эрдэнэбат нарын тавьсан асуултад Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Б.Заяабал үг хэлэв.

Б.Заяабал: Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төслийг зөвшилцөх асуудлыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 8

Бүгд: 20

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хорооны асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Я.Эрдэнэсамбуу, зөвлөх Л.Батмөнх, референт Б.Алтан, С.Тэгшжаргал, Х.Шижирмөнх нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Б.Заяабал танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Заяабал: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 8
Бүгд: 20
60.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 40 минут үргэлжилж, 32 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр 12 цаг 31 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.ЗАЯАБАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Заяабал: Байнгын хорооныхоо гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, 53 хувьтай ирц бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2026 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Бүртгэлд орсон Байнгын хорооны гишүүд хуралдааны танхимдаа бас хүрэлцэн ирэхийг урья.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдийнхээ нэрсийг танилцуулъя. Анар, Батболд, Батнайрамдал, Булгантуяа, Ганбаатар, Жамбалын Ганбаатар, Жавхлан, Заяабал, Лувсанжамц, Мандхай, Мэндсайхан, Мөнхсоёл, Соронзонболд, Ундраа, Уянгахишиг, Энх-Амгалан, Энхцэцэг, Эрдэнэбат нарын 17 гишүүд Байнгын хорооныхоо хуралдааны ирцэд одоогоор орсон байна.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 2 асуудал байгаа.

1.Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын “Санхүүжилтийн ерөнхий төлөвлөгөө”-ний төсөл хэлэлцэнэ.

2 дугаарт нь “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоол байгаа. Энэ нь бол Соронзонболд нарын 13 гишүүн өргөн мэдүүлсэн Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулахаар байгаа. Ийм 2 асуудлыг хэлэлцэхээр байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу. Саналтай гишүүн байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Эхний асуудал.

Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төслийг танилцуулна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Сангийн сайд Загджавын Мэндсайхан, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга гэсэн ийм бүрэлдэхүүн байна.

Одоо Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Загджавын Мэндсайхан танилцуулна. Мэндсайхан сайдын микрофон өгье.

3.Мэндсайхан: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Олон улсын геополитикийн хурцадмал нөхцөл байдал нь дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлж, эрчим хүч, хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт, олон улсын санхүүгийн зах зээлд сөргөөр нөлөөлж байна.

Эдгээр гадаад хүчин зүйлс нь улс орнуудын инфляцыг өсгөж төсөвт төлбөрийн тэнцэл болон гадаад валютын нөөцөд ихээхэн дарамт учруулж байгаа бөгөөд Монгол Улсын эдийн засаг ч мөн адил тодорхой эрсдэлүүдийг үүсгэж байна.

Иймд гадаад шокийн нөлөөллийг бууруулах, төсөв, төлбөрийн тэнцэлд үзүүлэх сөрөг нөлөөллийг саармагжуулах, шаардлагатай үед шуурхай ашиглах боломжтой санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор Сангийн яам, Азийн хөгжлийн банктai хамтран 450 сая ам.долларын санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн төслийг хэлэлцэн боловсруулж, 2026 оны 8 дугаар сарын 19-ний өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн.

Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр нь 200 сая ам.долларын төсвийн дэмжлэгийн эх үүсвэр болон 250 сая ам.долларын болзошгүй гамшгийн үеийн зээлийн шугамаас бүрдэнэ.

Өнгөрсөн жилүүдэд Азийн хөгжлийн банкнаас Монгол Улсад 100 сая ам.доллар хүртэлх төсвийн дэмжлэгийн зээлийг олгож ирсэн бол энэ удаагийн яриа хэлэлцээрийн үр дүнд 200 сая ам.доллар буюу 100 сая ам.доллaроор нэмэгдүүлж, үүнээс 50 сая ам.долларыг нэн хөнгөлөлттэй нөхцөлөөр олгохоор тохиролцоод байна.

Харин болзошгүй зээлийн шугамын хувьд 2024 оны зудын гамшиг тохиолдсоны дараагаас гамшгийн үе болон эдийн засаг, санхүүгийн хямралын үед ашиглах санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэхээр Азийн хөгжлийн банктai хамтран холбогдох судалгааг гүйцэтгэн гэрээ хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлыг хангаад байна. Энэхүү зээлийн шугам нь эдийн засгийн гадаад шок, байгалийн гамшиг, эрчим хүчний нийлүүлэлтийн систем болон хүнсний хангамжийн доголдолтой холбоотой онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд шаардлагатай санхүүжилтийг цаг алдалгүй татах боломжийг бүрдүүлэх юм.

Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн зээлийн нөхцөлийн хувьд хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийн зээл нь тогтмол 2 хувийн хүүтэй, 25 жилийн хугацаатай, эхний 5 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөнө. Энгийн эх үүсвэрийн зээл нь софер татвар нэмэх нь 0,5 хувийн хөвөгч хүүтэй, 15 жилийн хугацаатай, эхний 3 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөнө.

Уг санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр нь Монгол Улсын Их Хурлын 2025 оны 49 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг болон Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд заасан нь Засгийн газрын өрийн хязгаарт нийцэж байгаа болно.

Иймд санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн төсөл болон тус хөтөлбөрт гарын үсэг зурах эрх олгох тухай Ерөнхий сайдын захирамжийн төсөлтэй танилцан хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Б.Заяабал: Баярлалаа. Одоо Монгол Улс болон Азийн хөгжлийн банкны хоорондын “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төслийн зөвшилцөх асуудалтай холбогдуулан асуулт асуух гишүүдийн нэрс авъя. Гишүүд нэрсээ өгнө үү. Соронзонболд гишүүнээр тасаллаа. Ирцийн дагуу Ганбаатар гишүүний микрофон өгье. Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: Сангийн яамныхнаас асууя. Бид нарт чинь энэ нийт өр ДНБ-ий хэмжээ дандаа 2025 оноор байгаа. Их Хурлын гишүүдэд. Тэгэхээр 2026 оны гүйцэтгэлээр одоо яг хэд болж байгаа юм. Одоо ДНБ-ий хэмжээ. 100 тэрбум давсан уу, 100 их наяд. Тэгээд Засгийн газрын өр ярьж байгаа шүү. Засгийн газрын өр тэр хүрээндээ бид нар чинь дээд хязгаар гээд тавьсан. Тэгээд энэ авах гэж байгаа зээл маань тэрэнтэйгээ яаж нийцэж байгаа вэ. Би бол хариултыг нь мэдэж байгаа л даа. Ер нь тэгэхдээ Эдийн засгийн байнгын хороон дээр ялангуяа анх сонгогдсон гишүүд гэдэг юм уу, ер нь ард иргэд мэдэж байх ёстой. Би бол хариултаа мэдэж байгаа. Тэгэхдээ ер нь бараг өөрөө хариулдаг юм л даа сүүлдээ. Тэгээд энэ 200 сая доллар чинь 2026 онд ашиглагдах юм байна. 2026 он ингээд Их Хурлаар орох байх аа энэ чинь. Тэгээд амжих уу гэдэг асуулт асууя.

Амжаад тэгээд жилийн эцэст яг юунд хэрэглэх гэж байгаа вэ гэдгийг Сангийн сайдын тайлбараас би бол яг тодорхой ойлгосонгүй. Ер нь бол нөхцөл байдал хүндэрвэл гэнэтийн зүйлд л хэрэглэнэ гэсэн. Энэ чинь их бүрхэг байна л даа. Энийг бол анх удаа асуугаагүй. Би бол энэ зээлийг яг яригдаж байхад нь хэтэрхий бүрхэг байна. Тэгээд тийм сонин асуугаад л, хариулаад л өнгөрдөг юм л даа. Бараг загнаад шахуу л өнгөрчихдөг юм. 700-аад тэрбум төгрөгийн асуудал байна. Ийм хэдэн асуулт асуугаад, тэгээд хариулт аваад тодотгоё. Баярлалаа.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон өгье.

С.Тулга: Тулга Сангийн яам. Гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын өрийн хэмжээ 2025 оны гүйцэтгэлээр 35,4 их наяд буюу ДНБ-ий 39,4 хувьтай тэнцэж байсан бол энэ оны эхний хагас жилийн байдлаар 36,2 их наяд буюу ДНБ-ий 35,5 хувьтай тэнцэж байгаа. Оны эцсээр өрийн хэмжээ ДНБ-ий 44,5 хувьтай тэнцэнэ гэж үзэж байгаа. Энэ зээл болон тодотголыг дагаад нэмэгдүүлж байгаа дотоод үнэт цаас 1 их наяд төгрөг. Тэгээд үүн дээрээ нэмэгдээд энэ ондоо хувийн хэвшлүүдээ 1 тэрбум хүртэлх ам.долларын Засгийн газрын өрийн баталгаа гаргана гэж тооцох юм бол дотоодын нийт төгрөгийн 44,5 хувьтай тэнцэнэ гэж тооцож байгаа. Энэ зээлийн маань зорилго болохоор 2 зорилготой байгаа.

1 талдаа бол энэ валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилготой байгаа. Энэ жил Монголбанкны мэдээллээр бол арилжааны банкнууд 500 хүртэлх сая долларын эргэн төлөлт хийгдэнэ. Энэ бол төлбөрийн тэнцэл, валютын нөөц дээр тодорхой хэмжээнд нөлөөтэй учраас энэ дээр эерэг нөлөө үзүүлнэ.

Нөгөө талдаа бол энэ бол шууд төрийн сангийн мөнгөн хөрөнгийг нэмэгдүүлээд явчихна. Энэ бол улирлын чанартай мөнгөн хөрөнгийн дутагдлыг нөхөх зориулалттай ийм зээл байгаа. 150 сая ам.доллар нь болохлоор софер дээр нэмэх нь 0,5 буюу 4,1 хувийн хүүтэй, 50 сая долларыг нь Азийн хөгжлийн банктай гэрээ хэлцэл хийж байгаад нэн хөнгөлөлттэй нөхцөлөөр буюу 2 хувийн тогтмол хүүтэй авахаар ингээд тохиролцсон байгаа.

Б.Заяабал: Бусад асуултуудад дэлгэрэнгүй хариулт өгөөрэй. Ганбаатар гишүүний микрофон өгье. Нэмэлт тодруулга.

Ж.Ганбаатар: Тэгээд өөрөө асуугаад, өөрөө хариулдаг. Би бол уг нь Байнгын хорооны дарга аа ингэдэг юм. 4 минутаа өөрөө менежмент хийх эрхийг гишүүдэд олгох ёстой байхгүй юу. Тэгэхгүй бол тэгээд л асуугаад ихэнх минут нь явчихна. Тодруулах нь 1 минут. Тэгэхээр ер нь тэгээд өөрөө 1 минут асуугаад, 3 минут

тодруулах бололцоотой. Энийг уг нь дэгд өөрчлөлт оруулаад, одоо ингээд дууслаа л даа.

Би ДНБ-ий хэмжээ асуусан бид нарт бол янз янзын тоо энд, тэндээс өгдөг. Тэгэхдээ Сангийн яам хариулах хэрэгтэй.

2 дугаарт 12 сардаа амжих юм уу, үгүй юу. Юу хийх гэж байгаа юм бэ гэж асуусан. Одоо энэ Их Хурлаар ороод, тэрийг жоохон дэлгэрэнгүй тайлбарлаач би бас яг энийг чинь өмнөх хурал дээр нь бас ингэж асуусан. Тэгээд тодорхой хариулт аваагүй. Бараг жилийн өмнө билүү дээ. Тэгэхээр энэ дээр хариулт өг дөө. Би ахиад тодруулъя даа.

Б.Заяабал: 6 номер ажлын хэсэг.

С.Тулга: Тулгаа Сангийн яам. Гишүүний асуултад тодруулга өгье. ДНБ энэ оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 102,4 их наяд төгрөгт хүрнэ гэж Эдийн засаг, хөгжлийн яамнаас тооцож байгаа. Энэ хөтөлбөрийн зээлийн хувьд бол 3 Байнгын хороогоор ороод, буцаагаад Ерөнхий сайдад эрх олгох Байнгын хорооны шийдвэр нь Засгийн газар дээр очоод, Засгийн газар дээр гарын үсэг зурсны дараа буцаагаад Их Хурал руу орж ирж соёрхон батлагддаг. Бидний хүлээгдэж байгаа хугацаа бол 10 сард гарын үсэг зурах Их Хурлын тогтоол соёрхон батлагдвал 11, 12 сардаа бол энэ зээлээ ашиглаад явчихна гэсэн ийм хүлээлттэй байгаа. Энэ нь болохоор төсвийн тодотголтой хамт бас Их Хуралд өргөн барьсан ийм зээлийн санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр байгаа.

Б.Заяабал: Ганбаатар гишүүнд нэмэлт тодруулга.

Ж.Ганбаатар: Энэ жил ингэж яарах хэрэг байгаа юм уу. Тэгээд л дараа жилийнхээ юунд хэрэглэхгүй юу. Заавал энэ чинь одоо 2029 он хүртэлх байх аа. Тэгэхээр би бол одоо ингээд яаруу сандруу хэрэглэх гээд, тэгээд яг юунд хэрэглэх гэж байгаа нь ойлгогдохгүй. Тэгээд Их Хурлын гишүүдэд тийм болзошгүй эрсдэлд зориулна гээд л. Түрүүн чинь л бас ингэж хариулж байсан юм. Тэгээд 200 сая доллар гэдэг чинь 700-аад тэрбум төгрөг. Тэгээд наадах чинь соёрхон баталсаар байтал. Тэгээд яагаад эрт оруулж ирж болоогүй юм. Яагаад ер нь бол Сангийн яам байнгын төсвийн тодотгол хийнэ гэдэг чинь Сангийн яам тооцоолол буруу хийж байна шүү дээ. Бид нар байна шүү дээ Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам 2-ын уялдааг хангахын тулд төсвийн хүрээг 4 сард ярьдаг. Төсвийг 9 сард өргөн барьдаг, энийг чинь бид нар маш удаан ярьж байж хийсэн шүү дээ. Тэгээд одоо яг өргөн баригдаж байгаа энэ Төсвийн байнгын хороо дээр ярих гэж байгаа асуудлаар чинь..../минут дуусав/

Б.Заяабал: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон.

С.Тулга: Тулгаа Сангийн яам. Нэмэлт хариулт өгье. Ганбаатар гишүүний хэлж байгаагаар энэ болзошгүй гамшгийн үед ашиглах зээлийн шугам бол 2029 он хүртэл ашиглагдахаар байгаа. Тэгэхдээ энэ төсвийн дэмжлэг буюу 200 сая ам.долларын бидэнд 50 сая ам.долларын нэн хөнгөлөлттэй эх үүсвэрээр санхүүжүүлэхээр Азийн хөгжлийн банктэй тохироод, ер нь бол Засгийн газар, Азийн хөгжлийн банк 2 маш богино хугацаанд тохиролцоод оруулж ирж байгаа.

Энэ ондоо яагаад ашиглах гээд байгаа юм бэ гэхээр энэ 50 сая долларын нэн хөнгөлөлттэй нөхцөл нь энэ ондоо ер нь дуусгавар болохоор байгаа. Тэгээд Монгол

Улс энийг ашиглахгүй бол бусад өөр хөгжиж байгаа улсууд руу энэ нэн хөнгөлөлтийн эх үүсвэрээ хуваарилна гэж Азийн хөгжлийн банкнаас бол мэдэгдээд байгаа.

Гишүүн ээ, бид ер нь бол 1 жил орчмын хугацаанд Азийн хөгжлийн банктай хөөцөлдөж байгаад одоо ингээд л орж ирж байгаа.

Б.Заяабал: Лувсанжамц гишүүний микрофон олгоё.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе. Төсөв, санхүү, эдийн засгийг бэхжүүлэх төсвийн дэмжлэгийн зээлийн хөтөлбөр гээд энэ танилцуулга дээр хаалт дотор дэд хөтөлбөр 2 гэсэн байна. Энэ дэд хөтөлбөр 1 гэж эхнийх нь байсан уу. Энэ эхнийх дээр нь хэдий хэмжээний зээл аваад, түүний үр дүн нь яаж гарсан бэ. Тэгээд тэр дээрээ үндэслээд 2 дахийг нь бас авах гэж байгаа болов уу гэж ойлгож байна.

2 дахь асуулт нь болзошгүй гамшгийн үеийн санхүүжилт болон сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр гээд. Болзошгүй гамшиг дээрээ яг юу юуг тооцож байгаа вэ. Тэр зүйлүүдийг бас тодорхой юунд зарцуулах вэ гэдэг дээр тодорхой хариулт өгөхийг хүсэж байна.

Хэлэлцэх асуудалтай уялдуулаад бас нэмэлт асууя. Одоогийн байдлаар Монгол Улс Азийн хөгжлийн банкнаас хэдий хэмжээний зээл аваад байна вэ. Үүний ашиглалт нь ямар түвшинтэй байна. Зээл авсан ч гэсэн төсөл нь хэрэгжихгүй байдаг, эсвэл хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай тийм асуудлууд байгаа юу. Энэ дээр ерөнхий хариулт байхад болно.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон.

С.Тулга: Энэ төсвийн дэмжлэгийн 2 дугаар үе шат гээд эхний үе шатыг нь Лувсанжамц гишүүнээ юу яасан юм. 2023 онд авч ашигласан. 2022 онд гэрээгээ байгуулсан. Энэ нь бол яг нөгөө ковидын дараах үе дээр манайх бас валютын нөөц нэмэгдүүлэх, тэгээд мөнгөн хөрөнгөө нэмэгдүүлэх ийм зорилгоор Азийн хөгжлийн банкнаас анх удаа авч ашигласан, тэр банкнаас авсан төсвийн дэмжлэг байгаа.

Азийн хөгжлийн банкнаас нийт Монгол Улсын Засгийн газар 6,4 их наяд төгрөгийн зээл аваад, 46 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байна. Одоо бүх 46 төслийн хэрэгжилтийн хувийг харах юм бол 20 орчим хувьтай явж байна. 1,3 их наяд төгрөгийн ашиглалт гарсан байна. Үлдэгдэл 5,1 их наяд төгрөг ашиглагдаагүй үлдэгдэл байгаа. Азийн хөгжлийн банкны төслөөр санхүүжүүлж байгаа зээлүүдийн ашиглалт бол бусад төслүүдийг бодох бол харьцангуй бас удаашрал нь гайгүй байдаг. Тэгээд шаардлагатай бол дэлгэрэнгүй мэдээллийг танд бичгээр хүргүүлэе.

Б.Заяабал: Лувсанжамц гишүүнд нэмэлт микрофон олгоё.

Г.Лувсанжамц: Баярлалаа. Тэгвэл бичгээр бас Азийн хөгжлийн банкны талаар мэдээллүүдийг нь авъя гэж бодож байна. Европын сэргээн босголтын банк ч юм уу бусад бас нөгөө зээлийн шугамууд дээр ашиглалтаасаа бас харьцангуй Азийн хөгжлийн банкны хувьд бол илүү байгаа гэж ойлголоо. Тэгэхээр бусдынхаа мэдээллийг нь бас харьцуулсан байдлаар мэдээлэл хүргүүлэхийг хүсэж байна.

2 дахь асуулт болох болзошгүй гамшгийн үеийн санхүүжилт гэж байгаа. Энэ дээр болзошгүй гэдгийг яг ямар зүйлүүдийг тодорхойлж байгаа вэ. Тэр дээрээ тодруулъя.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон.

С.Тулга: Болзошгүй гамшгийн үед энэ бол Азийн хөгжлийн банкны санхүүгийн нэг хэрэгсэл. Энэ бол өмнө нь яаж ашиглагддаг байсан гэхээр тухайн улс оронд газар хөдлөлт, цунами, хуй салхи, ойн түймэр иймэрхүү үйл явдлууд тохиогоод, эдийн засагт нь томоохон хэмжээний хохирол учирсан, энэ нь индикатораа давсан тохиолдолд ашигладаг байсан. Энийг бол Азийн хөгжлийн банктай бид нар оны эхнээс ярьж байгаад, түлш шатахууны доголдол, тэгээд хүнсний инфляц энэ нөлөөллүүдийг бас оруулж өгөөч, энэ нөхцөлд манайх энэ зээлийн шугамыг нээмээр байна гэсэн хүсэлтийг ирүүлж байгаад тэгээд яг энэ 2 нөхцөлийг бол нэмж өгсөн байгаа. Нийтдээ бол 3 нөхцөлтэй. Хэрвээ гамшгийн байгалийн үзэгдэл гарсан, 1 бол эрчим хүчний түлш шатахууны доголдол үүссэн, нөгөөдөх нь болохоор хүнсний инфляц инфляцад бодитой нөлөө үзүүлсэн гэдэг ийм 3 индикатор нэмж орж байгаа.

Б.Заяабал: Соронзонболд гишүүний микрофон олгоё.

Л.Соронзонболд: Тэгэхээр энэ төсвийн дэмжлэгийн хөтөлбөрт зарцуулна гэж байгаа. Тэгэхээр төсвийн алдагдал 2 их наяд төгрөг байхад манай Монгол Улсын төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл хэд байна вэ гэдэг асуулт байгаа. 1 дүгээрт.

2 дугаарт болохоор энэ төсвийн дэмжлэгийн хөтөлбөр 200 сая ам.долларыг болохоор ингээд зарцуулахдаа мөнгөн хөрөнгийн дутагдалд орсон саруудад ашиглах гээд байна шүү дээ. Тэгэхээр та бүхний тооцоолж байгаа тэр мөнгөн хөрөнгийн урсгал чинь дутагдалтай болох тэр үед төрийн сангийн чинь дундаж үлдэгдэл сарын дундаж үлдэгдэл хэд байх гээд байгаа юм. Ямар тохиолдолд ашиглах гээд байна гэсэн асуулт байхгүй юу.

Нөгөөдөх нь болохоор юу гэж асуугаад байна вэ гэхээр одоо бид нарын энэ зээлэх гээд байгаа яг энэ төсвийн дэмжлэгийн зорилгоор ашигласан өөр ямар зээл байгаа вэ. Тэр зээлүүдийн ашиглалт хэр байгаа вэ. Тэгээд энэ төсвийн дэмжлэгт ашиглах гээд байгаа 200 сая ам.долларыгоо төрийн сангийнхаа дундаж үлдэгдэлтэйгээ харьцуулаад үзэхээр харьцаа маань ямар байгаа юм бэ гэсэн ийм одоо асуулт асууя.

Б.Заяабал: 6 номер. Ажлын хэсгийн 6 номер.

С.Тулга: Тулгаа сангийн яам. Соронзонболд гишүүнд яг энэ мэдээллүүдийг бичгээр хүргүүлъя. Яг одоо энийг бол Төрийн сангийн газрынх нь даргаас бас тодруулах шаардлагатай байна. Над дээр бол яг одоо төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл хэд байгаа гэдэг мэдээлэл нь бас байхгүй байгаа. Тэгэхээр энийг бол яг нарийн тоон мэдээлэлтэй нь бичгээр өгье.

Ашиглалтын зорилго нь бол Соронзонболд гишүүн хэллээ. Энэ бол энэ оны сүүлийн 12, тэгээд 1, 2 сарууд дээр хэрвээ мөнгөн хөрөнгийн дутагдал үүсгэх юм бол энэ мөнгийг ашиглана гэсэн ийм зориулалтаар авч байгаа.

Б.Заяабал: Соронзонболд гишүүний микрофон өгье.

Л.Соронзонболд: Тэгээд гол нь ингээд байхгүй юу. Та хэд чинь одоо дутагдал үүсэх гээд байна гээд тооцоод байгаа юм бол тэр тооцоо чинь хэд юм бэ л гэж асуугаад байна шүү дээ. Тухайн дутагдал ашиг гарах гээд байгаа саруудын төрийн сангийн мөнгөний дундаж үлдэгдэл хэд байх юм бэ гэдгийг тооцож байж та хэд чинь иймэрхүү хэмжээний мөнгөө зээлье гэж тооцож байгаа байлгүй. Тэр тооцоог л асуугаад байна.

Нөгөө талдаа болохоор ерөнхийдөө жилийн туршдаа төрийн сангийн мөнгөн хөрөнгийн дундаж үлдэгдэл ийм байна. Тэгэнгүүт бид нар төсвийн дэмжлэгийн зорилгоор ашиглах гээд байгаа 200 сая ам.доллароо бүтэн ашиглалаа гэх юм бол харьцаа маань ийм байх юм байна ч гэдэг юм уу ийм тооцоо байх ёстой л гээд байхгүй юу. Хувь хүмүүс жишээлбэл зүгээр зээлийн карт гэж байгаа шүү дээ. Зээлийн картыг бол мөнгөн хөрөнгө дутагдсан үедээ ашиглаж байгаа. Тэгэхдээ тэр хэмжээг нь тооцоход тухайн хүний орлоготой нь уялдуулж тооцож байгаа шүү дээ. Тэгэхээр манай дээр бол тиймэрхүү тооцоолол байх ёстой л гээд байхгүй юу Сангийн яаманд. Тэгээд тэрийгээ л хариулаач гээд байхгүй юу.

Б.Заяабал: 6 номер ажлын хэсэг.

С.Тулга: Төрийн сангийн мөнгөн хөрөнгө бол яах вэ, ер нь бол дунджаар 1,5-аас 2 их наяд төгрөг орчим дээр бид нар мөнгөн хөрөнгийг барьдаг. Энэ дээр нэмэгдүүлээд Соронзонболд гишүүн ээ юу байгаа юм. Гадаад зээлийн үндсэн төлбөр, дотоод бондын үндсэн төлбөр гээд энэ нөлөөллүүд бас мөнгөн хөрөнгө талдаа орж ирдэг. 9-12 сард дотоод бонд дээр 103 тэрбум төгрөг, гадаад зээл дээр 577, хүүгийн төлбөрт дотоод бонд дээр, гадаад бонд, гадаад зээл нийлээд 475 тэрбум, ингээд 1 их наяд орчим төгрөгийн мөнгөн хөрөнгийн эффект зээлийн төлөлт тал дээр гарч ирж байгаа учраас энэ тал дээрээ бас нөхөх ач холбогдолтой байгаа. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл бол ер нь бол Төрийн сан дээр 1,5-2 их наяд орчим дээр Сангийн яам ингээд барьдаг.

Б.Заяабал: Мөнхсоёл гишүүний микрофон олгоё.

Б.Мөнхсоёл: 2 л гол зүйл дээр төвлөрч асууя. Нэгдүгээрх нь ханшийн хэлбэлзэл. Хувийн сектор бизнесийнхэн юуг бас ач холбогдол өгч харж байна вэ гэхээр ханшийг тогтвортой байлгаад өгөөч ядаж гэдэг ийм хүсэлт байгаа шүү дээ. Гэтэл энэ Засгийн газрын өрийн 96 хувь нь дандаа гадаад валютаар хийгдсэн буюу ханшаас хамааралтай. Эрсдэл өндөр гэсэн үг. Тэр ханшийн хэлбэлзэлтэй эрсдэл өндөр байгаа нь эргээд нөгөө өндрөөр яригдаад байгаа инфляцын түвшиндээ нөлөөлнө. Энэ талаар ямар арга хэмжээ авахаар байдалтай байна вэ.

2 дугаарт нь төлбөрийн ачаалал түрүүн бас гишүүд асууж байна. Тэгэхээр 2027 оны төсвийн тухай хуулийн төсөл дээр зээлийн үндсэн төлбөрт 5,99 их наяд төгрөг төлөвлөөд, зөвхөн энэ зээлийн хүүгийн төлбөрт 1,573 их наяд төгрөг төлөвлөж байна шүү дээ. Тэгээд энэ 5,99 их наяд чинь өмнөх жилүүдтэй харьцуулахад 3-4 дахин их байна. Тэгэхээр энэ дээр яг бодит боломж юу гэж тооцоолж байгаа вэ. Бид нар ингээд хурлаас хуралд ингээд аргалаад хариулт асуусан, хариулсан болоод өнгөрдөг бодит байдал дээр гишүүдийн хэлээд байгаа зүйлүүд биеллээ олчихдог. Тэгээд 1 ийм асуудлаас асуудалд яваад байна шүү гэдгийг бас хэлэх нь зүйтэй байх.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон хариулъя.

С.Тулга: Сангийн яам Тулга. Тэгээд Мөнхсоёл гишүүний хэлж байгаа бол зөв. Одоо Засгийн газрын нийт өрийн дийлэнх хэсгийг нь бол гадаад өр эзэлж байгаа. Ийм ч учраас Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр өрийн дээд хязгаар 60 байгааг бид нар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл дээр 50 гэж оруулж ирж, ерөнхийдөө дунд хугацаандаа ДНБ-ий 10 орчим хувьтай тэнцэх хэмжээний эрсдэлийг тооцож ингэж авч явдаг байгаа. Гадаад өрийн хэмжээг Засгийн газар үе шаттай бууруулахаар зорилт тавиад явж байна. 2026 онд дотоод бондын хэмжээ 561 байсныг энэ оны тодотголоор 1 их наяд төгрөгөөр нэмэгдүүлэх, 2027 онд 2 их наяд төгрөгөөр нэмэгдүүлэх, ер нь бол гадаад, дотоод зээлийн харьцааг 80/20 дээр аваачих ийм дунд хугацааны зорилт Засгийн газар тавиад явж байгаа.

Төв банк дээр бол ханшны гол бодлого явж байгаа. Тэгэхдээ Засгийн газрын зүгээс энэ дээр ямар дэмжлэг үзүүлдэг вэ гэхээр нэгд яг иймэрхүү төсвийн дэмжлэг буюу гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх ийм эх үүсвэрүүд олж ирэх, хямд эх үүсвэртэй, хямд өртөгтэй. 2-т болохлоор манайх гадаад бондын эргэн төлөлтийг төв банкны валютын нөөц дээр томоохон хэмжээний дарамт үүсгэхгүйн тулд дандаа дахин санхүүжүүлээд явж байгаа. Тэгээд тодорхой хэмжээг нь төлөөд тодорхой дийлэнх хэсгийг нь дахин санхүүжүүлэх энэ бодлогыг баримтлаад явж байгаа. Тэгээд ирэх оны 7 сард бол Засгийн газар 430 сая долларын эргэн төлөлттэй. Энэ дээр бол бас тодорхой хэмжээнд дахин санхүүжүүлээд явна.

Мөнхсоёл гишүүний хэлдэг үндсэн төлбөр дотор энэ гадаад бондын төлбөр бүхэлдээ орчихсон учраас ингэж өндөр харагдаж байгаа. Эндээс бол 430 сая доллар дээр дахин санхүүжүүлэлт хийнэ. Энэ дээр бас нөгөө нийслэлийн 500 сая долларын Сэлбэ дэд төвийн эргэн төлөлт 8 сар байгаа. Энэ 2 ингээд дахин санхүүжүүлэх учраас яг эргэн төлөлт бол 5,9 их наяд дээр бол очихгүй Мөнхсоёл гишүүн ээ.

Б.Заяабал: Мөнхсоёл гишүүн тодруулга авах уу.

Б.Мөнхсоёл: Төслийн зээл 3,88 их наяд гэж байгаа шүү дээ. Тэр бол ороогүй биз дээ.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон.

С.Тулга: Мөнхсоёл гишүүний ярьж байгаа нь бол гадаад зээлээ ашиглалт юм байна. Эргэн төлөлт биш. Эргэн төлөлт талдаа бол 2026 онд гадаад зээлийн эргэн төлөлт 1,6 их наяд байгаа. 2027 онд 1,8 их наяд байгаа.

Б.Заяабал: Эрдэнэбат гишүүн микрофон өгье.

С.Эрдэнэбат: 1 дүгээр асуулт. Энэ зээлийн шугамыг ер нь авах үндсэн нөхцөл чинь ер нь бараг хангагдчихсан юм болов уу гэж би бодоод байна. Ер нь авна гэж төлөвлөж байгаа. Та хэд бол зээлийн шугамыг нээххээд хэрэгтэй үед нь бол ямар ч байсан авна гэж байгаа ийм байдлаар яриад байгаа. Тэгэхдээ одоо ингээд харахад үнийн өсөлт, түлшний үнэ, гадаад төлбөрийн тэнцэл, хэрэглээний үнэ энэ тэр гээд бүх энэ авах нөхцөл чинь бол үндсэндээ хангагдчихаад байна шүү дээ. Тийм үү. Тэгэхээр үндсэндээ Их Хурлаар шийдвэр гаргуулаад, шууд энэ хүсэлтээ Азийн хөгжлийн банк руу өгөөд, зээлээ ер нь бол авч хэрэглэнэ гэдгээр тооцож байгаа вэ. 1 дүгээр асуулт.

Хоёрдугаарх нь байгалийн гамшиг, гэнэтийн осол аваар, эрчим хүчний дутагдал гээд. Би түрүү жил улсын төсөв дээр баахан ярьж байж санд нь мөнгө байгаа байхгүй юу. ХАБ-ын сан гээд 400-аад тэрбум төгрөг уг нь байгаа юм. Одоо Жавхлан сайд бол мэдэж байгаа. Би нөгөө байнга ХАБ ярьдаг. Манай Мэндсайхан сайд, 2 сайд сууж байна. Түрүү жил энэний өмнөх жил ХАБ дээр тэр эрсдэлтэй байгаа станцууд дээрээ үнэлгээ, дүгнэлт хийгээд, энд гарах ёстой зардлуудыг нь гарга гээд хэлээд 400 сая төгрөг тавьсан уу, яалаа. Тавиагүй л дээ үндсэндээ. Тэгсэн чинь дараа нь яг хэлсэн юм шиг станц дэлбэрээд 100 тэрбумын 3 дугаар станц чинь үндсэндээ 100 тэрбумын асуудалтай болсон. Үгүй ээ, Монгол улс өөрөө төсөв дээрээ ... солиороод байх юу байдаг юм та. Та мөнгө тавиагүйгээс болоод энэ гамшиг асуудал гарвал гаднаас мөнгө зээлж, амраар нь гаднаас мөнгө зээлээд, байх ёстой санг нь зарцуулж чадахгүй, тэгсэн мөртөө гамшиг гарвал осол аваар, эрчим хүчний дутагдал гарвал гаднаас зээл авъя гэж байна шүү дээ. Дахиад наад станц чинь 8, 9 турбин байгаа. Ослын байдалтай байгаа. Тийм учраас зарим гарах ёстой энэ зардлуудаа гарга Мэндсайхан сайд аа. Би Хөдөлмөрийн сайдаас чинь зөндөө асуудал тавиад, үндсэн байгаа зориулалтын сангуудыг нь зараад, заавал осол, гамшиг юм гарсны дараа гаднаас мөнгө зээлэх үү гэдэг биш, яаж урьдчилан сэргийлэх вэ, байгаа зориулалтынх нь сангийн юмнуудыг нь зориулалтаар нь зарж байвал яасан юм бэ л гэж юм хэлэх гээд байна шүү дээ. Энэ дээр солиороод байх юм байхгүй ээ Жавхлан сайд аа. Хүн нас барсан шүү дээ. 1 хүн нас барсан. 100 тэрбумын юу байсан, өч төчнөөн хохирол учирсан. Одоо дахиад осол аваар гарангуут нь үндсэн зориулалтын сангуудын мөнгө зарахгүй байж байгаад, гамшиг гараад станц гэдэг юм уу, осол аваар гарсан тохиолдолд гаднаас зээлчихье гэдэг энэ арга барил чинь нэг талаараа бас буруу шүү гэдгийг л би анхааруулж хэлэх гээд байгаа юм. Тийм учраас Сангийн сайд маань эрсдэлээс сэргийлэх өөрийн боломжит сангууд чинь бас тодорхой хэмжээгээр байгаа. Тийм учраас би энэ дээр нь зүгээр анхааруулж хэлэх гэсэн юм.

Тийм учраас тухайлбал эрчим хүчний дутагдал гээд ярьж байна. Татаас гээд орж ирж байгаа. Тийшээ явах гэж байна уу. Түлш шатахуун гээд байж байгаа. Махны үнэ рүү явах уу. Одоо махны нөөц бүрдүүлнэ. Бид нар чинь тийм төлөвлөгөө хийж байгаа. Тэгээд яг юунд зарцуулах гэж байгаа вэ гэдгээ тодорхой хэлээд өгөөч гэж хэлмээр байна.

С.Заяабал: Сангийн сайдын микрофон өгье. Сангийн сайд хариулъя.

3.Мэндсайхан: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Энэ зээлийг аваад зарцуулах гэж байгаа, аюулгүй нөөц бүрдүүлэх чиглэлээр зарцуулах гэж байгаа 250 сая долларыг бол манайхан маш сайн тайлбарлаад байгаа шүү дээ. Гамшигт нөхцөлийн үед, эрсдэл үүссэн үед таны яриад байгаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор авах гэж байгаа зээлийн шугам. Түүнээс биш энэ зээлийг шууд авчихна гэж байгаа асуудал биш шүү дээ. Зээлийн эрхээ нээчихье. Ямар нэгэн эрсдэл үүсэхэд бид нар зохион байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авахад бэлэн байя гэж байгаа юм. Нөгөө талдаа энэ дээр манайхан хүсэлт гаргаад хүнс, шатахууны нөөц бүрдүүлэх энэ чиглэл дээр эрсдэл үүсэх юм бол энийг хэрэглэе гэдэг энэ хүсэлтийг АХБ-нд тавиад хангуулсан.

Тэгээд эрчим хүчний салбар дээр аюулгүйн нөөц бүрдүүлээгүйгээс болоод станц дээр дэлбэрчихсэн юм шиг юм ярьж болохгүй ээ. Эрчим хүчний салбар чинь аж ахуйн тооцоотой аж ахуйн салбар. ТӨК-ууд бие даасан засаглалаа явуулж байгаа үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг, бизнес төлөвлөгөөгөө, жилийн

төлөвлөгөөгөө ТУЗ-өөрөө батлаад хэлэлцээд явдаг. Түүгээрээ асуудлаа шийдээд явдаг.

2 дугаарт Байнгын хорооны индэр ашиглаад та замбараагүй ийм мэдэгдэл хийхээ болиорой. 7, 8 турбин дэлбэрэхэд бэлэн байж байгаа гэж юу ярьж байна. Та бид 2 энийг хоёулаа мэдэхгүй шүү. Тэр эрчим хүчний сайдаас нь асуугаарай. Өвөлжилтийн бэлтгэл ажил хангах гээд Засгийн газар байдаг бүхнээ шавхаж байхад та энэ дээр станц дэлбэрэх гэж байгаа гэж юу яриад зогсож байгаа юм.

Б.Заяабал: Эрдэнэбат гишүүн тодруулга.

С.Эрдэнэбат: Би станцаар бас ажилчидтай уулздаг хүн. Мэргэжлийн хүмүүсээс бас зөвлөгөө авдаг хүн. Насаараа л тэр ажилчидтай уулзлаа. Үндсэндээ манай хуучин станцууд маань бас эрсдэлтэй байгаа гэдгийг Засгийн газрын хурал дээр ч гэсэн тэр Онцгой комиссынхон очиж ажиллах үеэр ч гэсэн хэлсэн шүү дээ мэргэжлийн хүмүүс нь. Ер нь бол техникийн хувьд бид нар эрчим хүчиндээ хөрөнгө оруулах хэрэгтэй тодорхой хэмжээнд гэдгийг л би хэлж байна. Энд уурлаад ингээд байх юм байхгүй шүү дээ 1 дүгээрт.

2 дугаарт тухайн байгууллага нь зөвхөн тэр ХАБ-ын асуудлыг ярьдаг юм биш. Монгол Улсын Засгийн газар өөрөө улсын төсвийнхөө хуулиар 0,5 хувийг нь аюулгүй байдалд зарцуулах ёстой гээд хуультай. Би бас ХАБ-ын асуудлаар бол бас 10, 20-оод жил ажилласан юм. Би бас би арай илүү мэдэх байх..../минут дуусав/

Б.Заяабал: Санал хэллээ. Гишүүд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн төслийн зөвшилцөх асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Үг хэлэх гишүүд байна уу. Алга байна.

Би бас товч үг хэлчихье. Ер нь ерөнхийдөө Ойрх Дорнод, Орос, Украины дайн гээд гадаад геополитикийн нөхцөл байдалтай холбоотой Монгол Улс шиг бас ийм хөгжиж байгаа болон буурай хөгжилтэй орнуудын хувьд ийм санхүүжилтийн гадаад валютын доголдолд орж байгаа. Үүнтэй холбоотой олон улсын байгууллагууд бас ийм хөнгөлөлттэй, төсвийн дэмжлэг үзүүлэх ийм зээлүүдийн сан нээсэн. Манай Монгол Улсын Сангийн яам, Засгийн газар бас энэ дээр хүсэлт өгч, АХБ-ных нь бол шийдэгдээд явж байгаа юм байна. Энэ бол софер дээр нэмэх нь 0,5 буюу одоо өгч байгаа, авч байгаа энэ зээлүүд, одоо бид нарын гадаад босгоод байгаа энэ бондууд, арилжааны банкны бусад бондуудаас ч хамаагүй бага хувийн хүүтэй, дээрээс нь тодорхой хувь нь бас хөнгөлөлтийн нөхцөлтэй юм байна. Хөнгөлөлтийн нөхцөлтэй орж ирж байгаа ийм зээл байна. Энийг бол бүх орон, бүх буурай болон хөгжилтэй орнууд бүгдээрээ энэ дээр санал хүсэлтээ гаргаж байгаа ийм зүйл юм байгаа юм. Тэгээд яг ийм хүнд нөхцөл байдал дээр эдийн засгийн ийм тодорхойгүй геополитикийн нөхцөл байдал дээр гадаад худалдаа, бусад нөхцөлүүдийгээ хангахын тулд улс орон болгон ийм хүсэлтүүдийг тавьж байгаа. Тэгээд энэ бол хөгжил рүү чиглэсэн төсөв рүү яг ийм хүнд үед чиглэсэн ийм зээл болж байгаа. Энэ агуулгаар нь бол миний хувьд дэмжиж байгаа гэдэг ийм үгээ хэлье.

Ингээд гишүүд үгээ хэлж дууслаа. Гишүүдийг санал хураалтад бэлдэхийг хүсье. Хурууны хээгээ уншуулж санал хураана. Бүртгэлийн санал хураалт явуулаадах уу. Үүрийнтуяа гишүүн бас орж ирж байгаа юм байна. Санал хураалтад гишүүд бэлтгэлээ.

Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төслийн зөвшилцөх асуудлыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд ээ. Санал хураалтад 20 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 60 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

12.27 цаг.

2 дугаар асуудалдаа оръё.

2 дугаар асуудал. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа.

Соронзонболд нарын 13 гишүүн өргөн мэдүүлсэн Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг бэлтгэсэн байгаа. Ажлын хэсгийн томьёоллыг гишүүдэд танилцуулсан. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу. Байхгүй байна.

Өмнөх асуудал дээр Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлж, санал, дүгнэлтийг унших ёстой. Санал, дүгнэлтийг унших гишүүн байна уу. Анар гишүүн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Байнгын хорооны санал дүгнэлтийг Анар гишүүн уншиж танилцуулна.

Үргэлжлүүлээд 2 дахь асуудал. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу. 2 дахь асуудал дээр байхгүй юу. Байхгүй байна. Санал хураалт явуулъя.

Ажлын хэсэг байгуулах тогтоолын төслийг танилцуулах ёстой юм байна. Танилцуулгыг Байнгын хорооны дарга уншиж танилцуулах ёстой юм байна. Байнгын хорооны тогтоолыг уншиж танилцуулъя.

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах, бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Үүрийнтуяа /Их Хурлын гишүүн/

Ажлын хэсгийн гишүүдэд Ц.Баатархүү, Батсүмбэрэл, Ундраа, Эрдэнэбат гэсэн ийм 4 гишүүний бүрэлдэхүүнтэй төлөвлөсөн байна. Нийт 5 гишүүний бүрэлдэхүүнтэй.

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг ажиллуулахыг ажлын хэсэг /Д.Үүрийнтуяа/-т зөвшөөрсүгэй.

Эдийн засгийн байнгын хороо гэсэн ийм тогтоолын төсөл байгаа юм. Тогтоолын төсөлтэй холбоотой үг хэлэх, асуулт асуух гишүүд байхгүй. Үг аваагүй учраас санал хураалтаа явуулж эхэлье. Гишүүдийг санал хураалтад бэлдэхийг хүсье.

Саналын томъёоллыг уншиж танилцуулъя. Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 60 хувь буюу 12 гишүүн дэмжлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Хуралдаандаа идэвхтэй оролцсон гишүүд, ажлын хэсэгт баярлалаа. Одоо Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хамтарсан хуралдаантай.

12.31 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ